



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар

1/26

Мандалговь

“Олгойн говь-1 орд газарт шинээр  
гүний худаг гаргаж, цахилгаан хангамж,  
цэвэр усны дамжуулах шугамын ажил”  
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний  
хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих “Олгойн говь-1 орд газарт шинээр гүний худаг гаргаж, цахилгаан хангамж, цэвэр усны дамжуулах шугамын ажил” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

О.Бархүү (Дундговь -Ус Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга )

Гишүүд:

Ж.Шинэ-Уянга (Хүнс хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга)

Б.Гарамханд (Орон нутгийн өмчийн газрын өмч хариуцсан мэргэжилтэн)

Б.Мижиддорж (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг:

Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (О.Бархүү)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Я.ДОРЖБАТ



4870150203